



УВС АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 6/102.

Улаангом

Шалгаруулж, урамшуулан шагнах
тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.4 дэх хэсгийн 136.4.2-ын "в", "е", "к", 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Тэргүүний болон шилдэг алба хаагч шалгаруулах /код 133/ журам"-ын 133.3.3, мөн оны А/248 дугаар тушаалаар баталсан "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам"-ын 900.3 дахь хэсгийн 900.3.4-ийн "д" заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачлага, ажлын өндөр амжилт, үр дүн гарган ажилласан алба хаагчдыг нэгдүгээр хавсралтаар баталж байгууллагын 2019 оны "Хөдөлмөрийн тэргүүний алба хаагч"-аар шалгаруулж, "Өргөмжлөл", албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиар,

2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлж, хамт олноо манлайлан ажилласан алба хаагчдыг хоёрдугаар хавсралтаар баталж, байгууллагын 2019 оны "Ажил мэргэжлийн шилдэг алба хаагч"-аар шалгаруулж, "Өргөмжлөл", албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар,

3. Хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, хэсгийн алба хаагч нарыг хошуучлан ажилласан алба хаагчдыг гуравдугаар хавсралтаар баталж, байгууллагын 2019 оны "Хэсгийн тэргүүний алба хаагч"-аар шалгаруулж, "Өргөмжлөл", албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар,

4. Эрхэлсэн ажилдаа амжилт, үр дүн гарган ажилласан алба хаагчдын нэрсийг дөрөвдүгээр хавсралтаар баталж, Цагдаагийн газрын "Баярын бичиг", албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар тус тус шагнаж урамшуулсугай.

5. Нэр бүхий 28 алба хаагчдын албан тушаалын сарын үндсэн цалинг хавсралтанд заасны дагуу 2019 оны 12 дугаар сард нэмж олгож, шагналын өргөмжлөл, баярын бичгийн үнэ 315000 /гурван зуун арван таван мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Б.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Мишигдорж/-д даалгасугай.
Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ

